

НҮҮДЭЛЧ МАЛЧДЫН СУУРЬШИХ ҮЙЛ ЯВЦ, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

Цэдэв-Ишийн Отгонхүү, Магистр, Эрдэм шинжилгээний дэд ажилтан¹

Даваахүүгийн Хишиндорж, Магистр, Эрдэм шинжилгээний дэд ажилтан¹

Пунсанцогвоогийн Цэенханд, Бакалавр, Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан¹

¹Шинжлэх Ухааны Академийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Нийгэм эдийн засгийн газарзүйн салбар

Хураангуй

Орчин үед нүүдлийн амьдралын хэв маягаас суурин амьдралын хэв маягт шилжих шилжилт давамгайлах болов. Энэхүү судалгаагаар 2016-2018 онд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 420 малчин өрхийн асуулгад боловсруулалт хийж хагас суурьшлын 3 хэлбэрийг илрүүлсэн. Эдгээр нь уламжлалт нүүдлийн тоо, зай цөөрч, нэг буурин дээрээ удаан сууж буй малчдын хагас суурьшил, ямар нэгэн суурин газар (сум, аймгийн төв, Улаанбаатар)-т өрх тасран амьдарч буй малчдын хагас суурьшил, хот орчмын бүсэд мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэрийг үүсгэн суурьшиж буй малчдын хагас суурьшил болно. Харин дэд бүтцийн сайтар хөгжилтэй суурин газарт зарим малчин өрхүүд суурьшиж, орлогын олон төрөлтэй болж буйгаар малчдын бүрэн суурьшил илэрч байна. Хөдөөгийн хүн ам бүрэн суурьшилд шилжиж буй 2 хэлбэр байна. Үүнд хатуу хучилттай авто зам дагуух зорчигчдод үйлчлэх үйлчилгээний цэгт болон хот суурин газарт шилжиж очиж, суурьшмал амьдралын хэв маяг руу шууд орж байна. Гэхдээ нутаг дэвсгэрийн ялгаа, байгалийн бүс бүслүүр, аж ахуй эрхлэлтийн онцлогоос хамааран суурьшлын хэлбэрүүд өөр өөр байгаа нь ажиглагдаж байна

Түлхүүр үгс: Хөдөөгийн суурьшил, малчин өрх, шилжилт хөдөлгөөн, хөдөөгийн суурьшлын хэв маяг

Abstract

Nowadays, moving from a nomadic lifestyle to a settled lifestyle prevails. The purpose of this study is to define the settlement process of nomadic herders in geographical terms and to determine their forms. In 2016-2018, 420 herder households were randomly selected and surveyed and 3 semi-settlement forms were identified. These include the herder households with long-term settlements in the same area with reduced mobility and distance, those living as split in some settlement areas (soum, province center and Ulaanbaatar city), the ones settled in peri-urban areas establishing a new form of farming and labor organization. In contrast, there are some herder families who are fully settled in areas with better infrastructure development and enabled diversified earning opportunities, demonstrating full settlement form. 2 forms of full settlement have been evident for rural community- moving to service areas for passengers along the autoroad network and moving to urban areas. However, the types of settlements have been observed to vary depending on the territorial differences, natural zones, and the specifics of the business.

Key words: Rural settlement, herder household, mobility, migration, rural settlement pattern

1. УДИРТГАЛ

Дэлхий дахинд нүүдлийн буюу хөдөөгийн, суурин буюу хотын, хоторхуу буюу завсрын гэсэн 3 янзын амьдралын хэв маяг оршин байгаа ба орчин үед нүүдлийн амьдралын хэв маягаас суурин амьдралын хэв маягт шилжих шилжилт аль ч бүс нутаг, улс орнуудад давамгайлах (Ж. Оюунгэрэл, 2004) болжээ.

Нүүдэлчдийн суурьших үйл явцад нийгэм-эдийн засгийн тодорхой нөхцөл шаардах учир улс бүхэнд өөрийн гэсэн онцлог хэлбэр, хугацаатай (Д. Базаргүр нар, 1990) явагдаж байна.

Манай орны нүүдэлч малчдын амьдралын хэв маягийг мал аж ахуй эрхэлж байгаа арга,

малын бэлчээр, тэжээлийн нөхцөл байдлаас хамаарч бүрэн нүүдэлчин, хагас нүүдэлчин, хагас суурьшил, бүрэн суурьшил гэж (Д.Базаргүр нар, 1990; С. Шийрэв-Адъяа, 1999) ангилна. Нүүдэлч малчдын суурьшлыг нийгэм эдийн засаг, байгаль орчны ашиглалтын олон асуудлыг хамарсан амьдралын нөхцөлийг сайжруулах үндсэн арга зам гэж ойлгох ба дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн сум, тосгон сууринд суурьшиж, нийгмийн асуудлаа шийдвэрлэж буйгаар илэрч байна (С.Шийрэв-Адъяа, 1999). Иймд нүүдэлч малчдын суурьших үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэхүү судалгааны ажилд Шинжлэх Ухааны Академийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнд гүйцэтгэж буй “Хөдөөгийн хүн амын суурьших үйл явцын газарзүйн судалгаа” (2017-2019) суурь судалгааны төслийн зарим үр дүнгээс ашигласан болно.

Нүүдэлч малчдын суурьшлын тухай ойлголт

Монгол улсын хот болон хөдөөгийн онцлог, иргэдийн соёл иргэншлийн төлөв хийгээд өрхийн аж байдал, амьжиргааны түвшинг харгалзан хот, хөдөөгийн амьдрал буюу суурин ба нүүдэлч гэсэн эрс ялгаатай амьдралын хоёр хэв маягийг тодорхойлжээ (Ц. Цэцэнбилэг нар, 2016).

Суурь судалгааны төслийн багийнхан бид Монгол орны нүүдэлч малчдын суурьших үйл явцын чиглэлээр хийгдсэн бүтээлүүдийг судалсны үндсэн дээр түүхэн гурван үед хувааж тоймлосон болно. Эдгээр нь:

Нэг: Нэгдэлжих хөдөлгөөний өмнөх үеийн малчдын суурьшлын чиглэлээр хийгдсэн судалгаанд малчдын нүүдлийн тоо, зай, хугацаа зэрэг орон зай, цаг хугацааны үзүүлэлтүүдийг байгалийн нөхцөлтэй холбон судалжээ. Тухайлбал өвөл, хаврын улиралд нүүх тоо цөөрч байгаа нь суурьшиж байгаагийн нэг илрэл болж байна (Н. Лхагважав, 1979). Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Төв, Хэнтий аймагт суурьших үйл явц идэвхтэй явагдаж (өвөлзуны нүүдэлтэй), хээр, говийн бүсэд нүүдлийн байдалтай аж төрөгсдийн тоо буурахгүй (Н. Жагварал, 1974) байна.

Хоёр: Манай оронд нэгдэлжих хөдөлгөөн үүсч хөгжсөн үед мал аж ахуйн байршилт, төрөлжилтийн асуудлаас үүдэн хөдөө аж ахуйг зохистой эрхлэн хөтлөх систем зэрэгтэй уялдуулан малчдын суурьшлыг ангилсан

байна. Тухайлбал, малчид бэлчээрийн мал аж ахуй эрхлэх явцдаа янз бүрийн нөхцөлд хөдөлмөрөө хорших, ээлжлэхээс эхлэн малынхаа бэлчээр нутгийг зөв сонгож тохируулснаар заавал малаа дагаж нүүхгүйгээр цөөн удаа, ойр зайнд нүүж, нэг буурин дээрээ удаан байж, улирлын түр суурьшлыг бий болгож (С. Шийрэв-Адъяа, 1999) байгаагаас гадна нэгдэл бүр газар тариалан, барилга, хадлан, туслах үйлдвэр эрхлэх тул малчид тодорхой мэргэжил эзэмшин нэгдлийн төвд бүрэн суурьших болжээ (Б. Гунгаадаш, 1986). Нүүдэлч малчдын суурьшилд шилжиж буй дараагийн хэлбэрт ажиллах хүчний хэрэгцээ шаардлагаар хот суурин газарт шилжиж буй шилжилт орно (М. Баянтөр, Х. Гантөмөр, 1971).

Гурав: 1990-д оноос хойш хийгдсэн судалгаануудад нүүдэлч малчдын суурьшилд нөлөөлөх байгаль, аж ахуй, нийгмийн хүчин зүйлүүдийг судалжээ. Тухайлбал, нүүдэлч малчдын хэтийн зорилго нь нийгмийнхээ асуудлыг хотын оршин суугчдаас дутуугүйгээр шийдэх (Д. Базаргүр, 2005) явдал бөгөөд нүүдэлчдийг төвлөрсөн суурьшилд шилжүүлэхэд (суурин амьдралд) хөдөөгийн тосгон чухал үүрэгтэй. Тэр нь хүмүүсийг өөртөө татаж, суурьшил үүсгэж, хотжилтыг бий (С. Шийрэв-Адъяа, 1999) болгоно. Нүүдэлч малчид нь суурьшихдаа суурин газрыг сонирхох, тэмүүлэх, шилжин очих, уусах гэсэн үе шатуудыг дамжиж байна (Д. Базаргүр, 2005). Зах зээлийн эдийн засагт шилжиж, мал хувийн өмчид шилжсэнээр нүүдэлч малчдын суурьшилд ихээхэн өөрчлөлт гарсан. Энэ нь малчдын шилжих тэмүүлэлтэй уялдан хот суурин газрын татах хүчин зүйлсийн хүрээнд амьдралын чанарын төлөө (Ж. Оюунгэрэл, 2004) хийгдэж буй шилжилт юм.

2. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Энэхүү судалгааны зорилго нь нүүдэлч малчдын суурьших үйл явцыг газарзүйн үүднээс тодорхойлж, түүний хэлбэрүүдийг тогтооход оршино. Тус судалгааг Монгол улсын нутаг дэвсгэрийн 38 хувийг эзлэх эдийн засгийн Төвийн бүс (Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Төв аймгууд) болон Зүүн бүс (Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд)-д явуулав.

Үндэсний Статистикийн Хорооны www.1212.mn сайтын мэдээллийн нэгдсэн сангаас 2012 ба 2017 оны нийт болон малчин өрхийн тоог авч ашигласан. Анхдагч мэдээ материал дээр

үндэслэн Үндэсний Статистикийн Хорооны даргын 2013 оны 1/149 тоот тушаалаар баталсан “Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг ашиглан Excel программ дээр боловсруулалтыг хийсэн.

Хээрийн судалгааг 2016-2018 онуудад аймгийн төв, хатуу хучилттай авто замаас алслагдсан байдал, байгалийн бүс, бүслүүрийг харгалзан сонгосон сумдад зохион байгуулж явуулсан. Нийт 6 аймгийн 16 сумаас хослосон түүврийн аргаар (ҮСХ, 2007) цуглуулсан малчин 420 өрх, сумын төвийн 200 өрхийн социологийн судалгааны асуумжаас өрхийн малын тоо, нүүдлийн тоо, зай, сургуулийн насны хүүхдийн тоо, өрх тасрах байдал (нөхөр нь хөдөө бага гэрээр малаа хариулж, эхнэр, хүүхдүүд нь 3 сар ба түүнээс дээш хугацаагаар тусдаа амьдрах), газар өмчлөл гэсэн асуултуудын хариулт тус бүрийг Excel программ дээр давтамж, хувийн жингээр илэрхийлж, ArcGIS программ дээр сэдэвчилсэн зураг зохиосон болно.

1. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нүүдэлч малчдын хагас суурьшлын хэлбэрүүдийг тодорхойлох

Хагас суурьшил гэдэг нь хот айлын бөөгнөрөл биш бөгөөд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд малчид байнга эсвэл жилийн ихэнх улиралд суурин амьдралд татагдан, тэмүүлж буйгаар илэрхийлэгдэх ойлголт юм. Томоохон амралт сувилал, жуулчны баазын ойролцоо, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу малчид орлогоо нэмэгдүүлэх зорилгоор нүүдэллэн ирдэг. Үүнээс шалтгаалан уламжлалт нүүдлийн тоо, давтамж цөөрч, нэг буурин дээрээ удаан сууж байгаагаар малчдын хагас суурьшил илэрч байна. Тухайлбал, Аварга тосон рашаан сувиллын орчимд сувилуулж эмчлүүлэхээр ирсэн амрагчдад гэр буудлаар үйлчлэх, цайны газар ажиллуулах, морь хөлсөөр унуулах, сүү, цагаан идээ, мах нийлүүлэх, Улаанбаатар-Дархан хүрэх авто замын дагуу зорчигчдод айраг, сүү, цагаан идээ зарах, нийслэлд мал аж ахуйн гаралтай түүхий эдээ борлуулахаар малчин өрхүүд зун, намрын улиралд (Фото 1) нүүдэллэн ирдэг байна.

Фото 1. Төв аймгийн Борнуур сумын орчимд малчдын зусланд буусан байдал



Эх сурвалж: Хээрийн судалгааны материал, 2016-2018

Энэ үйл явц малын тооноос ихээхэн хамаарч байгаа нь хээрийн судалгаанд санамсаргүй түүврээр сонгогдсон малчин өрхийн хариултаас ажиглагдсан. Малчин өрхийн малын тоо толгой багасах тутам жилд нүүх нүүдлийн тоо цөөрч буй зүй тогтол илэрч

байв. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 200 хүртэл малтай өрхийн 17.6 хувь нь огт нүүдэггүй бэлчээрээ сэлгэн ашигладаггүй бол 1001-ээс олон малтай өрхийн 47.7 хувь нь жилд 4-с олон удаа нүүдэллэж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан өрхийн нүүдлийн давтамж, малын бүлэглэлтээр

Малын тооны бүлэглэлт	Нүүдлийн тоо, давтамж								Бүгд
	Огт нүүдэггүй		1-2 удаа		3-4 удаа		4-өөс дээш		
	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь	
200 хүртэл	13	17.6	16	21.6	33	47.3	10	13.5	72
201-500	4	3.1	30	23.6	53	43.3	38	29.9	125
501-1000	5	3.5	23	16.3	71	51.8	40	28.4	139
1001-ээс олон	3	3.5	8	9.3	32	39.5	41	47.7	84
Бүгд	25	5.8	77	18.0	189	46.0	129	30.1	420

Эх сурвалж: Хээрийн судалгааны материал, 2016-2018

Цөөн буюу 200 хүртэл толгой малтай өрхүүд уламжлалт гэр сууцандаа нүүдэл хийхгүй жилийн 2-3 улирал (жилийн V-XI сард) суурьшиж аж төрж байхад 500 ба түүнээс дээш

малтай өрхүүд өвөлжөө, хаваржаан дээрээ байшин барьж, шаардлагатай үед оторт явах хэлбэрээр хагас суурьшлыг бий болгож байна (Фото 2).

Фото 2. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 2-р багийн малчин айлын өвөлжөө



Эх сурвалж: Хээрийн судалгааны материал, 2016-2018

Малчдын хагас суурьшлын дараагийн хэлбэр нь ямар нэгэн суурин газар (сум, аймгийн төв, Улаанбаатар)-т нийгэм эдийн засгийн шалтгааны улмаас малчид өрх тасран амьдарч буйгаар илэрч байна. Тухайлбал, судалгаанд

хамрагдсан малчин өрхийн 22.1 хувь (93 өрх) нь өрх тасран амьдардаг (Хүснэгт 2) ба тэдгээрийн 64.5 хувь (60 өрх) нь хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэх шалтгаантай байна.

Хүснэгт 2. Өрх тасрах байдал, сургуулийн насны хүүхэдтэй эсэхээр

Сургуулийн насны хүүхэдтэй эсэх	Асуулга авсан өрхийн тоо	Өрх тасрах байдал			
		Тийм		Үгүй	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
Тийм	200	68	34.0	132	66.0
Үгүй	220	25	11.4	195	88.6
Бүгд	420	93	22.1	327	77.9

Эх сурвалж: Хээрийн судалгааны материал, 2016-2018

2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжиж 6 настнууд ерөнхий боловсролын сургуульд элсэх болсноор бага насны хүүхэдтэй малчин өрхүүд илүү өрх тасарч амьдрах болсон. Жишээ нь, Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын 2-р багийн малчин өрхийн 42 хувь нь (21 өрх) ам бүлийн гишүүний тоо 1-ээр тоологдож байна. Эдгээр малчдын 52.4 хувь (11 өрх) нь гэр бүлтэй ба эхнэр, хүүхдүүд нь засаг захиргааны өөр нэгж (Говьсүмбэр аймгийн Баянтал, Сүмбэр сумд)-д бүртгэлтэй байв. Тус багийн малчин өрхийн 14 хувь нь (7 өрх) сумын төвд, 34 хувь нь (17 өрх) Говьсүмбэр аймагт, 2 хувь нь (1 өрх) нийслэл Улаанбаатарт өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгөтэй гэсэн байна. Нүүдэлч малчид өрх тасарч амьдарснаар эхнэр хүүхдээ эргэх, ирж очиход дөхөм байх үүднээс суурин газарт илүү ойр нутаглах болжээ.

Гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг бууруулах зорилгоор сум, орон нутгийн захиргаанаас сумын төвд малчдад гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлсэн явдал малчдын суурьшилд шилжих нэг шалтгаан болж байна. Энэ нь шилжих хөдөлгөөнийг бууруулж, малчдыг сумандаа үлдээж байгаа мэт арга хэмжээ боловч ирээдүйд эдгээр нүүдэлч малчид суурин амьдралын хэв маягт шилжихийг үгүйсгэх аргагүй. Өөрөөр хэлбэл, нүүдлийн мал аж ахуйгаас суурин аж ахуйн хэлбэр рүү шилжих шилжилтийн үе шатны нэгэн хэлбэр болж байна. Тухайлбал

судалгаанд хамрагдсан нийт өрхийн 38.8 хувь (163 өрх) нь суурин газарт газар өмчилж, өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй болжээ. Дээрх бүгдээс хот суурин газарт амьдрах малчин өрхүүдийн суурьшлыг 2 хэлбэрт хувааж үзэх боломжтой байна. Тодруулбал:

- Суурин газарт үл хөдлөх хөрөнгөтэй, хүүхэд багачууддаа боловсрол эзэмшүүлэх, ажил хөдөлмөр хийхээр өрх тасран амьдардаг өрх
- Хүүхэд багачууддаа боловсрол эзэмшүүлэх үүднээс өвлийн улиралд өрх тасран амьдардаг (айлын хашаанд) өрх

Хөдөөгийн малчид бүх малаа зарж дуусган гэрээ ачаад аймгийн төв, нийслэл Улаанбаатарт суурьших тохиолдол бараг байхгүй, харин малтайгаа хот орчмын бүсэд шилжин ирж, тухайн нутгийг дамжлага болгон ашиглаж байна. Малчин өрхүүд нь хоорондоо малаа ээлжлэн отроор хариулах, эсвэл цөөн малтай малчинд хөлсөөр хариулах зэрэг мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэрийг үүсгэж байна. Тэдний орлогын үндсэн эх үүсвэр нь бэлчээрийн мал аж ахуй байх нь улам бүр багасаж байгаа нь бүрэн суурьшилд шилжихийн өмнөх үе болж байна. Тухайлбал, аймгийн төв хүчтэй үйлчлэх орон зайд (40 хүртэл км) малчин өрхийн тооны өсөлт (44.6%) судалгаанд хамрагдсан нийт өрхийн өсөлт (24.4%)-өөс 2 дахин их байсан ба ийм шинж бүхий малчин өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин нэмэгдсэн байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Аймгийн төвийн алслалтаас хамаарсан малчин өрхийн тооны өөрчлөлт

Аймгийн төвөөс алслагдсан зай	Сумын тоо	Малчин өрхийн тооны өөрчлөлт, (2012/2017 он харьцуулсан %)	Нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь	
			2012	2017
Аймгийн төв	9	40.2	4.9	5.7
40 хүртэл км	10	44.6	17.3	30.8
41-80 км	17	17.6	41.6	46.1
81-120 км	25	24.7	40.9	46.3
121-ээс дээш км	64	21.6	32.1	35.7
Бүгд	125	24.4	22.8	25.5

Эх сурвалж: www.1212.mn


Хот орчмын бүсэд малчдын орлого амжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуйн салбар байх баталгаа улам багасч байна.

Нүүдэлч малчдын бүтэн суурьшлын хэлбэрүүдийг тодорхойлох

Энэхүү суурьшил нь дэд бүтэц сайн хөгжсөн суурин газарт суурьшиж, нийгмийн асуудлаа шийдвэрлэхээс гадна амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй байхаа больж, өрхийн орлогоо өөр олон салбараас бүрдүүлж буйгаар илэрнэ. Малчин өрхүүд орлогын өөр эх үүсвэр хайн хатуу хучилттай авто зам дагуух үйлчилгээний цэгт хүн амын бөөгнөрлийг үүсгэх нь хөдөөгийн хүн амын бүрэн суурьшлын нэг хэлбэр болно. Үйлчилгээний цэгүүдийн тоо жил ирэх тутам нэмэгдэж

байгаа ба газарзүйн зохистой байршилтай нь бусдаасаа илүү тэлж томрон, сумын төвийн хэмжээнд дүйцэхүйц болж, үйлчилгээний үүргүүд нь төрөлжиж байна. Малчин өрхийн эхнэр, хүүхдүүд нь зам дагуу бууж, гуанз ажиллуулж байхад нөхөр нь малаа хариулж, мах сүүгээ гуанзандаа нийлүүлнэ. Ийм айл, өрхүүд бэлэн мөнгөтэй болсон үедээ байшин барьж, малаа хөлсөөр айлд тавьж, бүрэн суурьшилд шилжсээр байна. Тухайлбал, энэхүү үйл явцыг Арвайхээр-Улаанбаатар-Чингис чиглэлийн улсын чанартай авто замын дагуух үйлчилгээний цэгүүдийн жишээгээр судалж үзэхэд 2017 онд нийт 24 үйлчилгээний цэгт 250 гаруй өрх, аж ахуйн нэгж суурьшин, үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд, 40 хувь нь мал аж ахуй эрхэлж байна (Зураг 1).

Зураг 1. Авто зам дагуух үйлчилгээний цэгүүдийн байршил



Эх сурвалж: Хээрийн судалгааны материал, 2016-2017

Монгол оронд нүүдэлч малчдын дунд хот эсвэл бусад суурин газар тийш тэмүүлсэн шилжих хөдөлгөөний хэлбэр хамгийн түгээмэл байна (Ж. Оюунгэрэл, 2004). Шилжилт тодорхой үе шаттай явагдах бөгөөд хөдөө нутгаас ойролцоох тосгон буюу жижиг хот руу, тэндээсээ том хот руу шилждэг байна (Х. Цэдэнсодном, 2003). Шилжигчдийн дийлэнх нь гэнэтийн үйл явдлаас бус эдийн засаг, гэр бүл, амьжиргаа, амьдралынхаа ахуй нөхцөлийг сайжруулах хүсэл тэмүүлэл, зорилгоос үүдэлтэйгээр шилжилт хөдөлгөөнд оролцож байгаа ба шилжин суурьшигч хүн амын томоохон хэсэг нь уугуул аймаг дотроо шилжиж байна.

Судалгаанд хамрагдсан сумын төвийн 200 өрхөөс 21.5 хувь нь (43 өрх) хөдөө нутгаас шилжиж ирсэн өрх байсан ба ажил олж хийх шаардлагаар 55.9 хувь, хот сууринд амьдардаг ах дүүгээ бараадах, тэдэнтэйгээ ойр амьдрах зорилгоор 28 хувь нь шилжин иржээ (Хүснэгт 4). Ахуйн хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр авах шалтгаан 6.9 хувь, томоохон хот суурин руу явахад ойр, зам дагуу оршдог, бэлчээр нутаг бараадан малаа дагаж гэсэн шалтгаанууд тус бүр 4.6 хувийг эзэлж байна. Харин боловсролын үйлчилгээ авах гэсэн шалтгааныг хүмүүс дурдаагүй байв.

Хүснэгт 4. Шилжин ирэгчдийн шалтгаан

Шалтгаан	Өрхийн тоо	Эзлэх хувь
Ахуйн хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр авах	3	6.9
Томоохон хот суурин руу явахад ойр, зам дагуу оршдог	2	4.6
Ажил олж хийх	24	55.9
Хүүхдэдээ илүү сайн боловсрол олгох	0	0
Хамаатан садангаа бараадах	12	28.0
Бэлчээрийн нутаг бараадан малаа дагаж	2	4.6
Бүгд	43	100

Эх сурвалж: Хээрийн судалгааны материал, 2016-2018

Шилжих хөдөлгөөний урсгал нь тухайн орны эдийн засгийн хөгжлийн түвшин, эдийн засгийн бүтцээс шалтгаалан байнга өөрчлөгдөж (ҮСХ, 2011) байдаг ба энэ хэлбэр нь манай орны нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн ялгааг харуулж байна.

2. ДҮГНЭЛТ

Орчин үед нүүдлийн амьдралын хэв маягаас суурин амьдралын хэв маягт шилжих нь давамгайлах болжээ. 2016-2018 онд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 420 малчин өрхийн асуулгад боловсруулалт хийж хагас суурьшлын 3 хэлбэрийг илрүүллээ. Үүнд, уламжлалт нүүдлийн тоо, зай цөөрч, нэг буурин дээрээ удаан сууж буй малчдын хагас суурьшил, ямар нэгэн суурин газар (сум, аймгийн төв, Улаанбаатар)-т өрх тасран амьдарч буй малчдын хагас суурьшил, хот орчмын бүсэд мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэрийг үүсгэн

суурьшиж буй малчдын хагас суурьшил болно. Харин дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн суурин газарт орлогын олон төрөлтэй болж буйгаар малчдын бүрэн суурьшил илэрч байна. Хөдөөгийн хүн ам бүрэн суурьшилд шилжиж буй 2 хэлбэр байна. Үүнд, хатуу хучилттай авто зам дагуух зорчигчдод үйлчлэх үйлчилгээний цэгт болон хот суурин газарт шилжин очиж, суурьшмал амьдралын хэв маяг руу шууд орж байна. Гэхдээ нутаг дэвсгэрийн ялгаа, байгалийн бүс бүслүүр, аж ахуй эрхлэлтийн онцлогоос хамааран суурьшлын хэлбэрүүд өөр өөр байгаа нь ажиглагдаж байна.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажил бичихэд үнэтэй зөвлөгөө өгсөн, түүвэр судалгаанд хамтран оролцсон “Хөдөөгийн хүн амын суурьших үйл явцын газарзүйн судалгаа” (2017-2019) суурь судалгааны төслийн багийн судлаач нартаа талархсанаа илэрхийлье.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Д. Базаргүр. 2005. Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй, хуудас 202, Улаанбаатар
- Д. Базаргүр, Б. Чинбат, С. Шийрэв-Адъяа. 1990. БНМАУ-ын малчдын нүүдэл, хуудас 26, Улаанбаатар
- М. Баянтөр, Х. Гантөмөр. 1971. БНМАУ-ын хот суурингийн 50 жил дэх өсөлт ба хот байгууламжийн газарзүйн зарим асуудал, МОГЗА №11. хуудас 203, Улаанбаатар
- Б. Гунгаадаш. 1986. БНМАУ-ын нийгэм эдийн засгийн газарзүй, хуудас, 201, Улаанбаатар
- Н. Жагварал. 1974. Аратство и аратское хозяйство, ст.77, Уланбатор
- С. Лувсандорж. 1967. Хөдөө аж ахуйн нэгдлийн сөл аж ахуй дахь хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлт, хуудас 108, Улаанбаатар
- Н. Лхагважав. 1979. Бэлчээрийг хуваарьтай ашиглах арга, хуудас 50, Улаанбаатар
- Ж. Оюунгэрэл. 2004. Нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл дэх Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд, хуудас 16, Улаанбаатар
- ҮСХ. 2011. Шилжих хөдөлгөөн ба суурьшил. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого, хуудас 204, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Улаанбаатар
- Х. Цэдэнсодном. 2003. Монголын хүн ам ба хүрээлэн буй орчин, хуудас 60, Улаанбаатар
- Ц. Цэцэнбилэг нар. 2017. Хөдөөгийн иргэдийн амьдралын хэв маяг: өөрчлөлт, хандлага. Суурь судалгааны төслийн тайлан, 2014-2016, хуудас 21, Улаанбаатар
- С. Шийрэв-Адъяа. 1999. Нүүдэлч малчдыг суурьшуулах газарзүйн зарим асуудал, хуудас 108, Улаанбаатар.